

АНУ-ын цэргийн командлал нисэгчгвй нисдэг аппаратын баазыг Африкийн баруун-хойд хэсэгт байгуулах товлотоотэй байна. Бүс нутагт «Аль-Каида» болон түүний хань хамсаатнуудын ажиллагааны тухай тагнуулын мэдээ баримт авах нисэгчгвй нисдэг аппаратуудыг баазад байрлуулна. Түүнийг Мали улсын зүүн хил орчмын Нигерийн нутаг дэвсгэрт байгуулах бололтой. Одоо энд францын цэрэг лалын зэвсэгт бүлгүүдийн эсрэг ажиллагаанд оролцож байна. Саналыг сайшаавал америкийн 300 орчим цэргийг Нигерт татан шилжүүлэх тухай үүний оно америкийн «Нью-Йорк таймс» сонин мэдээлсэн билээ. Түүнээс гадна ийм баазыг Буркина Фасод байгуулах хувилбрыг авч үзэж байна. Үүний хамт АНУ цэргийн албан хаагчдаа Хойд Африкт цэргийн ажиллагаанд оролцуулах гээгвйг Торийн департаментын толоологч Виктория Нуланд батлан илэрхийлэв.